



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.08.02 № 621
танай _____ ны № _____ т

**БУЛГАН АЙМГИЙН БАЯН-АГТ
СУМЫН СОНГУУЛИЙН
ХОРООНД**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Баян-Агт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Б.Нямбатын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-

006021287

2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.


Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Б.Нямбат Баян-Агт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Б.Нямбатын мөрийн хөтөлбөр (...*д*.....хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч Б.Нямбатад

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

**БУЛГАН АЙМГИЙН БАЯН-АГТ ИРГЭН БОЛДСАЙХАНЫ НЯМБАТЫН
2024 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД СОНГУУЛЬД
БИЕ ДААН НЭР ДЭВШИХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Нэг. Эрүүл мэнд

- 1.1 Хүнсний зориулалтын бус хуванцар савны хэрэглээг багасгах сургалт хийх
- 1.2 Эрт илрүүлэгт хамрагдалтыг өсгөж тогтмолжуулах бодлого баримтална
- 1.3 Эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн, спорт, нийтийн биеийн тамираар хичээллэх, эрүүл, зөв хооллох, өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх бодлого баримтална
- 1.4 Хүүхэд бие бялдар зөв дадал эзэмшиүүлэх зорилгоор стандартын тогтоолын талбайг сургуулийн орчимд байгуулах бодлого баримтална
- 1.5 Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн эргэлтийг нэмэгдүүлж, үний хөөрөгдлийг хязгаарлах бодлого баримтална.
- 1.6 Эмийн чанар, үнэ аюулгүй байдалтай холбоотой мэдээллийг цахимаар хянах боломжийг нэмэгдүүлж health.gov.mn цахим системийн хэрэглээг нэмэгдүүлэх бодлого баримтална

Хоёр. Боловсрол

- 2.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэг, сургуульд сурах орчин нөхцөл бүрдүүлэх бодлого баримтална
- 2.2 Ерөнхий боловсролын агуулга арга зүйд монголын түүх, хэл соёл, үндэсний уламжлал, нутгийн зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний хөгжил, төлөвшил, хос хэл сурахын ач тусыг тусган, хүүхдийг хөгжүүлэх амьдралын зөв дадал сургана.
- 2.3 Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, эрсдэлт бүлгийн сурагч нэг бүрд шаардлагатай дэмжлэг үзүүлэх, боловсролд тэгш хамруулах бодлого баримтална
- 2.4 Ерөнхий боловсролын сургуульд байгалийн ухаан, технологийн хичээлийн лабораторийн хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлж, туршилтын талбайг байгуулах бодлого баримтална
- 2.5 Сургуулийн өмнөх боловсрол, сургуулийн орчны камержуулалтыг нэмэгдүүлж, засварлах ажлыг үргэлжлүүлж хүүхэд аюулгүй, таатай очинд суралцах нөхцөл бүрдүүлэх бодлого баримтална
- 2.6 Спорт заал, дотуур байр, сургуулийн давхар бүрт коридорт хүүхэд ус уух боломжоор хангагдсан ус буцалгагч байршуулах бодлого баримтална
- 2.7 Сурагчдын дотуур байрны зөөлөн эдлэл, ширээ сандал, шкафыг шинэчлэх хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого баримтална
- 2.8 Сурагчийн дотуур байраны гал тогоог стандарт болгох бодлого баримтална
- 2.9 Бусад орон нутгийн багш нартай багшийг туршлага судлуулах, шинэ арга барил эзэмшихэд нь зориулж багш солилцоон ажиллуулах бодлого баримтална.

Гурав. Гэр бүл

- 3.1 Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг бий болгох зорилгын хүрээнд сургалт зохион байгуулах бодлого баримтална

Дөрөв. Цахилгаан эрчим хүч

- 4.1 Байгалийн сэргээгдэх эрчим ашигладаг гэрлээр сумын төвийн гадаа гэрэлтүүлгийг үе шаттай солих бодлого баримтална
- 4.2 Цахилгааны хүчдэлийн уналт ихтэй газарт трансформатор суурилуулах бодлого баримтална

Тав. Аялал жуулчлал

- 5.1 Хануй рашааны хүрмэнд оруулсан нойлын үйл ажиллагааг гэрээ байгуулан иргэн, аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлэх бодлого баримтална
- 5.2 Аялал жуулчлалын бүсэд тэмээ морь, сарлаг унуулах үйлчилгээг бий болгох
- 5.3 Монгол нүүдлийн аж ахуй өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, малчин өрийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор “малчин айлын гэр түрээс” бий болгох бодлого баримтална
- 5.4 Баян-Агт сумын онцлогийг шингээсэн гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжиж аялагч, жуулчдад худалдаалах нөхцөлийг бүрдүүлэх бодлого баримтална
- 5.5 Цагаан идээ, мах ашиглан Баян-Агт сумын нэрийн бүтээгдэхүүнийг бий болгож, байнгын болон түр үйл ажиллагаа явуулдаг дэлгүүрүүдэд тогтмол худалдаалах нөхцөл бүрдүүлэх бодлого баримтална

Зургаа. МАА, Хөдөө аж ахуй

- 6.1 Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлэх бодлого баримтална
- 6.2 Баг бүрийн өвс тэжээлийн ауулахад нөөц бэлтгэх бодлого баримтална
- 6.3 Малын тоо толгойн албан татвараар хийгдэж байгаа ажлуудыг иргэдэд сурталчилж, иргэдийн саналд тулгуурласан ажил үйлчилгээг төлөвлөх бодлого баримтална
- 6.4 Өрхийн аж ахуй өндөг, зөгийн аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжиж өргөжүүлэх бодлого баримтална
- 6.5 Хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах иргэдийн дэмжиж сумын иргэдийн хэрэгцээг хангах бодлого баримтална.
- 6.6 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үдийн хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүнийг хэрэглээг нэмэгдүүлэх бодлого баримтална
- 6.7 Ерөнхий боловсролын сургуулийн орчинд сурагчдад эрүүл, чанартай, хямд хоол цайгаар үйлчлэх цайны газар бий болгох бодлого баримтална